

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Д.БАТМӨНХ ТАНАА

2020.02.27 № 06/615
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн зохицуулагч Д.Батмөнх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 20-ноос 2020 оны 2 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нийслэл аудит ХХК-ийн аудитор Д.Ариунбулган, Чанарын хяналтын менежер С.Сэрчхорол, аудиторын туслах Ц.Гантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн №007 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл нь 2019 онд нийт 210 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төслийн удирдах хороогоор батлуулсан ба үүнээс 169 бүрэн хэрэгжиж, 28 үйл ажиллагааны хэрэгжилт хараахан эхлэж амжаагүй ба 2019 төслийн хэрэгжилт 80.41% байна. Харин зарцуулалтын хувь хэмжээний хувьд тайлант онд 7,313,240.00 мянган төгрөгийн төсвийг батлуулж 5,807,124.37 мянган төгрөгийн зарцуулалт хийж 79.41% байна.

Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

Бүрэлдэхүүн А: Макро эдийн засаг болон Төсвийн удирдлагыг бэхжүүлэх – 2,710,000 ам.доллар

А1 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд, Сангийн яамны хэрэглэгчдэд зориулан программ хангамж боловсруулан, төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд албан ёсоор холбогдон, ТЕГ, ГЕГ, НДЕГ-уудын мэдээллийн сангаас хэрэгцээт мэдээллийг авч эхлэсэн байна. Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүд, орлогын албан татвар, шууд татвар болон импортын тарифыг багтаасан статистик Тоологдох Ерөнхий тэнцвэрийг загвар (CGE)-ыг Microsoft Visual Studio программ дээр хөгжүүлсэн. Макро эдийн засгийн тооцооллын программчлалыг сайжруулан, 2019 оны уул уурхайн салбарын олборлолт, экспорт болон салбарын өсөлтийг тооцоолоод байна.

А2 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулсан. Төсвийн орлого төлөвлөлтөд ашиглах төсвийн орлогын төсөөллийн шинэчилсэн загварыг боловсруулсан байна.

А3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд, ӨУМС-ийн сайжруулалтыг хийж, хуучин хувилбар болох 6.1.2-ийг 6.1.3 болон өөрчилсөн ба туршилт, суурилуулалтын ажил хийгдсэн. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн дунд хугацааны төлөвлөлт болон 2019 оны Улсын нэгдсэн төсөвт тусгах мэдээллүүдийг гарган нэгтгэсэн. Хөгжлийн санхүүжилтийн газарт ашиглах 2 программ хангамжийн үүрэг функцийг гаргасан. Хөгжлийн санхүүжилттэй холбоотой бодлогын баримт бичиг, 2 журмын төслийг боловсруулсан байна.

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Инфосистемс" программыг санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянан үзэхэд үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,789,684.0 мянган төгрөгөөс тооцон 115,793.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт тус байгууллагын хувьд харьцангуй бага эрсдэлтэй гэж үзэн материаллаг байдлын түвшинг хоёр хувиар сонгосон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Төсөв, Санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 283,654.7 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,560,828.8	1,854,578.5	293,749.7
Нийт хөрөнгө	1,586,039.7	1,869,694.4	283,654.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,586,039.7	1,869,694.4	283,654.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,586,039.72	1,869,694.38	283,654.7

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,869,694.4 мянган төгрөг болж 283,654.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 7,313,240.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 6,889,240.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 424,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 7,313,240.0 мянган төгрөгийг гадаадын зээлийн санхүүжилтийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,794,866.48 мянган төгрөг буюу 79.2 хувьтай байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж үнэлэхэд алдаа зөрчилтэй асуудал гараагүй ба аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” төсөл тайлант онд нийт 14 удаагийн татан авалтаар 2,273.6 мянган ам доллар буюу 6,075,572.6 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч 6,889.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 424,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн байсан. Үүнээс 5,807,124.4 мянган төгрөгийн зарцуулалт хийгдсэн буюу нийт гүйцэтгэл 79.4 хувьтай байна. Дараагийн аудитаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын зарцуулалтыг нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Тус төсөл нь Сангийн сайдын 2016 оны 46 дугаар тушаалаар баталсан “Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож буй хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах” журмын дагуу нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт тооцогдоогүй бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийж байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тайлант жилд шилэн дансны цахим хуудсанд нийт 8 чиглэлээр 146 төрлийн мэдээллийг байршуулахаас 104 мэдээ буюу 71.2 хувийг цаг хугацаанд нь оруулж үлдэх 42 мэдээ буюу 28.8 хувийг хугацаа хожимдуулан байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж байхгүй болно.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Төсөв, Санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,560,828,838.09</u>	<u>1,854,578,498.61</u>
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	<u>1,560,828,838.09</u>	<u>1,854,578,498.61</u>
1.1.1	Кассанд байгаа бэлэн мөнгө		
1.1.2	Банкинд байгаа бэлэн мөнгө	<u>1,560,828,838.09</u>	<u>1,854,578,498.61</u>
1.1.2	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	429,550,321.93	516,024,160.72
1.1.3	Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	1,131,278,516.16	1,338,554,337.89
1.2	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
1.3	АВЛАГА	-	-
1.4	УРЬДЧИЛГАА	-	-
1.5	БАРАА МАТЕРИАЛ	-	-
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,210,884.37</u>	<u>15,115,882.82</u>
2	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>25,210,884.37</u>	<u>15,115,882.82</u>
2.1	Биет хөрөнгө	<u>25,210,884.37</u>	<u>8,902,966.15</u>
2.1.1	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,210,884.37	9,997,934.00
2.1.1	Хуримтлагдсан элэгдэл (МТТ)		(4,026,945.64)
2.1.2	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	3,742,950.37
2.1.2	Хуримтлагдсан элэгдэл (Тавилга, эд хогшил)		(810,972.58)
2.2	Биет бус хөрөнгө	-	<u>6,212,916.67</u>
2.2.1	Програм хангамж	-	11,470,000.00
2.2.1	Хуримтлагдсан элэгдэл	-	(5,257,083.33)
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,586,039,722.46</u>	<u>1,869,694,381.43</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
4.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		<u>2,398,600.00</u>
4.1.1	Богино хугацат өр төлбөр		2,398,600.00
4.2	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,586,039,722.46</u>	<u>1,867,295,781.43</u>
5.1	Засгийн газрын хувь оролцоо		
5.2	Хуримтлагдсан үр дүн	<u>1,586,039,722.46</u>	<u>1,867,295,781.43</u>
5.2.1	Өмнөх үеийн үр дүн	954,614,209.78	1,586,039,722.46
5.2.2	Тайлант үеийн үр дүн	631,425,512.68	281,256,058.97
5.2.3	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,586,039,722.46</u>	<u>1,869,694,381.43</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,037,681,119.76	6,088,616,146.66
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,037,681,119.76	6,088,616,146.66
	Нийтлэг татварын бус орлого	-	-
	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,037,681,119.76	6,088,616,146.66
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,610,453.01	13,043,551.18
	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,020,070,666.75	6,075,572,595.48
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,020,070,666.75	6,075,572,595.48
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,584,522,598.49	5,819,617,972.43
	УРСГАЛ ЗАРДАЛ	2,584,522,598.49	5,819,617,972.43
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,584,522,598.49	5,819,617,972.43
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,569,448.40	24,198,750.00
	Байрны түрээс	15,569,448.40	24,198,750.00
	Хангамж, бараа материалын зардал	302,055,407.26	50,270,866.35
	Бичиг хэрэг	6,918,250.00	37,729,493.00
	Тээвэр, шатахуун		
	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,687,928.22	12,541,373.35
	Ном, хэвлэл		
	Дотоод албан томилолт	295,503,479.04	
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,443,610,481.85	5,385,176,673.53
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,443,610,481.85	5,385,176,673.53
	Бараа үйлчилгээний бусад зардал	823,287,260.97	359,971,682.55
	Бараа үйлчилгээний бусад зардал	823,287,260.97	359,971,682.55
	Элэгдлийн зардал	-	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	453,158,521.27	268,998,174.23
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	185,406,494.84	12,257,884.74
	Гадаад валютийн ханшийн зөрүүний олз	185,406,494.84	12,257,884.74
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,139,503.43	-
	Гадаад валютийн ханшийн зөрүүний гарз	7,139,503.43	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	621,425,512.68	281,256,058.97

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,037,681,119.76	6,088,616,146.66
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,037,681,119.76	6,088,616,146.66
	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,037,681,119.76	6,088,616,146.66
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,610,453.01	13,043,551.18
	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,020,070,666.75	6,075,572,595.48
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,584,522,598.49	5,474,688,014.88
	УРСГАЛ ЗАРДАЛ	2,584,522,598.49	5,474,688,014.88
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,584,522,598.49	5,474,688,014.88
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,569,448.40	24,198,750.00
	Байрны түрээс	15,569,448.40	24,198,750.00
	Хангамж, бараа материалын зардал	302,055,407.26	50,270,866.35
	Бичиг хэрэг	3,864,000.00	37,729,493.00
	Тээвэр, шатахуун		
	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,687,928.22	12,541,373.35
	Ном, хэвлэл		
	Дотоод албан томилолт	295,503,479.04	
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,443,610,481.85	5,382,778,073.53
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,443,610,481.85	5,382,778,073.53
	Бараа үйлчилгээний бусад зардал	823,287,260.97	17,440,325.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	823,287,260.97	17,440,325.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	453,158,521.27	613,928,131.78
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	25,210,884.37	332,436,356.00
	Тоног төхөөрөмж	25,210,884.37	332,436,356.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(25,210,884.37)	(332,436,356.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	178,266,991.41	12,257,884.74
	Гадаад валютийн ханшийн зөрүүний олз	185,406,494.84	12,257,884.74
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	7,139,503.43	-
	Гадаад валютийн ханшийн зөрүүний гарз	7,139,503.43	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	606,214,628.31	293,749,660.52
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	954,614,209.78	1,560,828,838.09
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,560,828,838.09	1,854,578,498.61

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	954,614,209.78	954,614,209.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	631,425,512.68	631,425,512.68
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,586,039,722.46	1,586,039,722.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,586,039,722.46	1,586,039,722.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	0.00	00.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	0.00	00.00	281,256,058.97	281,256,058.97
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,867,295,781.43	1,867,295,781.43

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,313,240,000.00	5,794,866,486.14	1,518,373,513.86	79.2
УРСГАЛ ЗАРДАЛ	6,889,240,000.00	5,462,430,130.14	1,426,809,869.86	79.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,889,240,000.00	5,462,430,130.14	1,426,809,869.86	79.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
Байрны түрээс				
Бичиг хэрэг				
Тээвэр, шатахуун				
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр				
Томилолт, зочны зардал				
Дотоод албан томилолт				
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,889,240,000.00	5,462,430,130.14	1,426,809,869.86	79.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,834,880,000.00	5,457,247,689.88	1,377,632,310.12	79.8
Бараа үйлчилгээний бусад зардал	54,360,000.00	17,440,325.00	36,919,675.00	32.1
Ханшийн зөрүү		(12,257,884.74)	(12,257,884.74)	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	424,000,000.00	332,436,356.00	91,563,644.00	78.4
Тоног төхөөрөмж	424,000,000.00	332,436,356.00	91,563,644.00	78.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,313,240,000.00	6,088,616,146.66	1,224,623,853.34	83.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		13,043,551.18	(13,043,551.18)	
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,313,240,000.00	6,075,572,595.48	1,237,667,404.52	83.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,560,828,838.09		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,854,578,498.61		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6		

